

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

НОМЫН САН

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

2021 №03



Эмхэтгэсэн: Номзүйч С.Найгалмаа

М.Золбоо

Улаанбаатар хот

2021 он

ГАРЧИГ

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
ГЕОЛОГИ, ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....	2
ХӨДӨӨ АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААН.....	2
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	3
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	4-8
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	8-10
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	11-12
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	12-18
ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ.	18-20
БОЛОВСРОЛ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН.....	21
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	21-26
АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ.....	27
УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ.....	27
УРАН ЗОХИОЛ.....	29-30
ШАШИН СУДЛАЛ.....	30-33
ГҮН УХААН.....	33-34
СЭТГЭЛ СУДЛАЛ.....	35
НОМЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА.....	35-36
ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ, ЗОХИОЛ.....	36-47

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ- Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/

НХУУТ- Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим- I,II /211, 108 тоот/

ГНОФ- Гэрээр ном олгох фонд-I,II,III /110,201,401 тоот/

ГФ- Гадаад номын фонд /411 тоот/

ЛавФ- Лавлагааны фонд /409 тоот/

ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/

БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/

ХЗС- Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/

ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын
сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Цэдэнбаяр Д. **Сонгодог вольтерийн оператор** / Ред. Л.Хадхүү, Р.Энхбат; Техник ред. Т.Баяртөгс.- УБ., 2021.- 80х.- ISBN 978-99978-3-725-7.



Энэхүү бүтээлд шугаман операторын ерөнхий онол, гильбертийн огторгуйд операторын тоон муж, тоон радиусын тухай зарим үндсэн теоремуудын сонгодог баталгаа, резольвент нөхцөлүүдийг (Крайс, Ритт) судалсан судалгаа мөн функциональ огторгуйд Вольтерийн операторын чанарууд (компакт байх, норм, хосмог, циклик ба аккретив) пенсильн зэргээр зааглагдах нөхцөлүүд, (Чезаро, Абел, Крайсийн утгаарх зааглалт) квазинильпотент операторын спектрал анализ, Лагерийн олон гишүүнтийн хэрэглээ, Вольтерийн оператороор төрөгдсөн бүлийн тоон мужийг дүрслэх, тоон радиусын талаарх шинэлэг үр дүнгүүд болон шийдэгдээгүй зарим бодлогуудыг нэгтгэн оруулжээ.


22.162

Ц 94

/БУУТ-7/

ЭШФ Т 24549-24551

Сангаа Д., Уянга Э. **Соронзон** / Ред. Э.Дамдинсүрэн; Техник ред. И.Хишигдэмбэрэл, Б.Энхмэнд, Ц.Цог-Очир; Эх бэлт. П.Номинцэцэг; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 317х.- ISBN 978-9919-20-426-6.



Энэхүү бүтээлд нано соронзонгийн орчин үеийн онол, хэмжилт туршилтын аргууд, эрдэм шинжилгээний судалгааны үр дүнгүүд, соронзон материалын олон талт хэрэглээний талаар дэлгэрэнгүй тусгажээ.

22.33

С 293

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т 24546-24548

Ерөнхий физик: Цахилгаан соронзны лабораторийн ажлууд / Ред. Д.Улам-Оргих; Хэвлэлийн ред. Т.Ууганбаяр; Зураг схем М.Ананд.- УБ., 2021.- 205х.- ISBN 978-9919-504-47-2.



Энэхүү бүтээлд өмнө нь техникийн хувьд хийх боломжгүй байсан бөгөөд шууд бүртгэн хэмжиж байгаагүй цахилгаан соронзны зарим хэмжигдэхүүнийг шууд бүртгэн авч судлах шинэ ажлуудыг багтаав. Тухайлбал цэнэгүүдийн харилцан үйлчлэлийн хүч, цахилгаан орны хүчлэг, индукцийн гүйдэл, хүчдэл зэрэг хэмжигдэхүүнийг эдгээр ажилд шууд хэмжиж бүртгэн судалдаг. Сургалтын хөтөлбөрийн агуулгад өмнө нь багтаж байгаагүй цахилгаан ба соронзон орон доторх бөөмийн хөдөлгөөн, дамжуулагчийн доторх соронзон орныг судлах зэрэг ажлууд мөн хэмжилтийн үр дүнг боловсруулах тухай сэдэвт хамаарагдах зааврыг жишээтэйгээр оруулжээ.

22.33я7

Е 701

/БУУТ-3/

ЭШФ Т 24663-24664

ГЕОЛОГИ. ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН



Монгол орны экосистем ба биологийн төрөл зүйлд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөө, өнөөгийн төлөв байдал: Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл / Хян. Б.Нямбаяр, Я.Жамбалжав, Ш.Анармаа, А.Саруулзаяа; Эмхт. С.Вандандорж, Б.Долгор, Г.Цогт-Эрдэнэ, Г.Уламбаяр.- УБ., 2021.- 194х.- ISBN 978-9919-25-173-4.

Энэхүү бүтээлд "Монгол орны экосистем ба биологийн төрөл зүйлд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөө, өнөөгийн төлөв байдал" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан 30 гаруй эрдэмтэн судлаачдын ажлууд багтжээ.

26.23я43

М 692

/БУУТ-2/

ЭШФ Т 24706-24707



Түгжсүрэн Н. Агаар мандлын ухааны хэллэг, нэр томъёоны монгол-орос-англи толь бичиг / Эхийг хэвлэлд бэлт. Т.Одбаяр, Т.Одгал, Т.Одгалбаяр ба бус.; Хэвлэлийн эх бэлт. О.Болор; Диз. Э.Доржханд; Хян. Ж.Батбаяр, Ц.Адъяасүрэн, Ц.Баатарчулуун; Гишүүд Д.Дагвадорж, С.Дэмбэрэл, А.Намхай ба бус.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 352х.- ISBN 978-9919-24-243-5.

Энэхүү тольд агаар мандлын ухааны гол ойлголтууд нь цаг уур, одон орон, астрофизик, газарзүй, техникийн ухааны төрөл бүрийн сэдэвтэй холбогдох нь түгээмэл тул тэдгээр салбарын үг хэллэг, нэр томъёог тусгаснаас гадна физик тогтмолын тоон утга, нэгж болоод хамтарсан үйл ажиллагаа эрхэлж болох дэлхийн ба олон улсын төрөлжсөн гол байгууллага, судалгааны хүрээлэн, төв нийгэмлэгийн нэрсийг толийн төгсгөлд хавсаргажээ.

26.233я2

Т 74

/НХУУТ-3, ГНОФ-5/

ЭШФ Б 30536-30537

ХӨДӨӨ АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААН



Жамъянсүрэн С. Ойн генетик-селекции, үрийн аж ахуйн нэр томъёоны товч тайлбар толь=Краткий толковый словарь терминов по лесной генетике, селекции и семеноводству=Brief explanatory dictionary of terms on forest genetics, selections and seed science / Ариутган шүүсэн Т.Ариунбаатар; Уйгаржин бичгийг ариутган шүүсэн Ү.Доржоо; Зохиомжийг шийдвэрлэсэн Д.Давааням.- УБ.: Пресслоорд, 2021.- 478х.

Энэхүү толь бичигт 1276 нэр томъёоны тайлбарыг багтаасны дээр ойн генетик, селекции, үрийн аж ахуйд түгээмэл хэрэглэгддэг үгсийг түлхүү оруулж тайлбарлахыг зорилгоо.

43.4я2

Ж 239

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т 24668-24670

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Марико Б. **Япон дахь эмэгтэйчүүдийн талаарх бодлого:** Эрэгтэй эмэгтэйн хамтын ухамсарт оролцоот нийгэм ба хүүхдийн тоо цөөрч байгаатай холбогдуулан авч байгаа бодлогын араас / Орч. Э.Тогтуун; Хян. Д.Цэдэв.- УБ.: Удам соёл, 2021.- 302х.- ISBN 978-9919-24-318-0.



Тус номонд өнөөг хүртэлх Японы нийгэм дэх эрэгтэй эмэгтэйн хамтын ухамсарт оролцооны бодлого, ялангуяа 1945 оноос хойших улс төрийн бодлогын шилжилт өөрчлөлтийг эмэгтэйчүүдийн эрхийг хүндлэн дээдлэх, ялгаварлан гадуурхахыг хасах жинхэнэ нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх, нийгмийн тасралтгүй шинжтэй гүнзгий хамааралтай төрөлт багасалтын эсрэг авах арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн эмэгтэйчүүдийн нийгмийн хамгааллыг хэрхэн зохицуулах хойд Европын болон Европын орнууд, Америк, Солонгос дахь хүүхэд харах бодлого, эмэгтэйчүүдийн талаарх бодлого, түүний цаана байгаа ард иргэдийн амьдрал, түүнийг ухамсарлан ойлгож байгаа байдлыг харьцуулан авч үзсэний дээр Япон ба Америкийн удирдах албаны эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлага зэргийг багтаажээ.

60.54

М 26

/НХУУТ-5, ГНОФ-3/

ЭШФ 24543-24545

Мөнхбат С., Мөнхбат О. **Эрүүл мэндийн зан үйл, салбарын шинэчлэл:** Эрүүл мэндийн социологийн шинжилгээ / Ред. О.Чимэдсүрэн.- УБ.: МУИС хэвлэх, 2017.- 174х.- ISBN 978-99929-2-947-6.



Энэ бүтээл нь Монгол орон дахь орчин үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөгжил, нийгмийн дэвшил (1), Эрүүл мэндийн социаль хүчин зүйлийн шинжилгээ, анагаахын тусламж үйлчилгээ эрэлхийлэх социологийн учир шалтгаан (2), Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нь (3) гэсэн үндсэн 3 бүлэгтэй бөгөөд эрүүл мэндийн социологийн шинжилгээ, судалгаанд суурилсан тус салбарын бодлогын шинэчлэл хийхэд цогцоор нь авч үзэх олон санаа, дүгнэлт, зөвлөмжийг тусгажээ.

60.56

М 816

Цахим ном- 7596

Түмэндэлгэр С. **Жендэр ба нийгэм: Социологиор төсөөлөхүй** / Эх бэлт. Э.Хүслэн; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 172х.- ISBN 978-9919-21-169-1.




"Жендэр ба нийгэм: социологиор төсөөлөхүй" гэсэн энэхүү бүтээл уншигч танд шинээр сэтгэж, шинэлэг соёл, үзэл хандлага, амьдралын хэв маяг, зан үйлийг төлөвшүүлэхэд лавтайяа тус болно хэмээн найдаж байна. Зохиолд жендэрийн харилцааг тайлбарлах социологийн онолын хандлагуудыг авч үзээд, жендэрийн ялгааг нийгэмшилт, эдийн засаг, улс төр, гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл зэрэг нийгмийн институтийн үйл ажиллагаатай холбон цогц байдлаар судлахыг эрмэлзсэн нь энэ бүтээлийг улам сонирхолтой болгожээ.

60.56

Т 784

НХУУТ 75865-75867

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Чингис хааны өв, соёл / Эрхл. Х.Мэндсайхан; Хөрв. Х.Мэндсайхан; Хавтасны диз. Л.Энхтуяа.

Энэхүү бүтээлд Монгол улсын үндэсний номын сан, Монгол улсын үндэсний төв архивын хөмрөгт буй "Мянган алтан хүрдэт орчуулагч, Загарвадын хааны алтан навчит хэмээх түүх ба аймгийн ноёдын салбар", "Тэнгэрийн заяат Богд Чингис хааны домог оршвой", БН Чех улсын Масарикийн их сургуулийн гүн ухааны сургуулийн ази судлалын төвийн номын сангаас хуулбарласан "Чингис хааны үлгэр бөлгөө" зэрэг эх бичиг, сурвалжуудыг, Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн "Чингис хааны Алтан бичиг" эмхэтгэлээс Чингис хааны алтан, алаг, хар сүлдний сан, тахилгуудыг кирилл үсэгт хөрвүүлж, галиг, тайлбартайгаар оруулжээ.

63.2(1)

Ч 63



Боть I: Эх бичиг, сурвалжийн хөрвүүлэг тайлбар / Ред. Б.Нацагдорж; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Бичгийн галиг, тайлбар хийсэн Н.Саруул,

Г.Тайванжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 195х.- ISBN 978-9919-24-021-9.

ЭШФ Т 24726

Боть II: Олноо өргөгдсөн хаанаас дараалан олон монголчуудад хэрэглэгдэх түүх / Ред. Ц.Цэрэндорж; Эх бэлт. П.Энххүлэг; Хавтасны диз. Л.Энхтуяа; Бичгийн галиг, тайлбар хийсэн Х.Мэндсайхан, Ш.Мөнхбаатар.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 182х.- ISBN 978-9919-25-121-6.

ЭШФ Т 24727

Боть III: Цэвэгжавын Чингис хааны хураангуй шастир / Ред. О.Оюунжаргал; Эх бэлт. Т.Нарангуа; Эрхл. Х.Мэндсайхан; Хөрв. Х.Мэндсайхан; Бичгийн галиг, тайлбар хийсэн Х.Мэндсайхан.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 114х.- ISBN 978-9919-25-280-9.

ЭШФ Т 24728



Намсрай Н. Өөлдийн түүхийн соёл: Цувр. XIII: Өөлдийн соёл, түүхийн бичиг оршивой / Ред. М.Ганболд; Техник ред. Н.Ганболд; Эрхлэн хэвл. Н.Сэрээнэндорж, С.Баттулга; Эх бэлт. Ц.Амартүвшин.- 2 дахь хэвл.- УБ.: Бэмби сан, 2019- 340х.- (Өөлд судлалын нийгэмлэг ТББ. Улаанбаатар эрдэм их сургууль. Олон улсын Монгол судлалын салбар төв).- ISBN 978-9919-21-882-9.

Энэхүү бүтээл нь дөрвөн бүлгээс бүрдэх бөгөөд тэргүүн бүлэгт Өөлдүүдийн угсаа гарал, түүхийн тойм; дэд бүлэгт Өөлдийн уламжлалт аж ахуй; гуравдугаар бүлэгт Өөлд ардын эдийн соёл; дөрөвдүгээр бүлэгт Өөлд ардын оюуны соёл; тавдугаар бүлэгт Өөлдийн гар урлалын түүх соёлын талаар бичжээ.

63.3(1)

Н 271

/НХУУТ- 2/

ЭШФ Т 24629-24631

Ойрад Монголын түүх, соёлын асуудлууд: Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бичиг: №12 / Нягтлан зөвл. На.Сүхбаатар; Эмхэтгэж хэвл. Н.Наранжаргал, Д.Цэрэнжамц; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 104х.- ISBN 978-9919-23-972-5.



Тус эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэлд Ойрад монголчуудын түүх, соёл, угсаатны зүйн судалгаа, Ойрад монголчуудын хэл, бичиг, аман зохиолын судалгаа гэсэн 2 үндсэн асуудлыг хөндсөн өгүүллүүдийг сонгон оруулжээ.

63.3(1)я43

О 24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24622-24626

Пүрэвжав Э. Монголын нууц товчоон судлалын чуулган: Боть I / Хян. Ш.Чоймаа; Эх бэлт. П.Баясгалан; Диз. С.Мөнх-Очир.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 256х.- (Монгол улсын шинжлэх ухааны академи. Хэл зохиолын хүрээлэн).- ISBN: 978-99929-2-626-0.



Тус бүтээл нь үндсэн 4 бүлгээс бүрдэх бүрдэх бөгөөд Нэгдүгээр бүлэгт Монголын нууц товчооны монгол хэлний судалгаа; Хоёрдугаар бүлэгт Монголын нууц товчооны хөрвүүлэг орчуулга; Гуравдугаар бүлэгт Монголын нууц товчоон судлаач эрдэмтэд; Дөрөвдүгээр бүлэгт Монголын нууц товчоон судлалын өгүүллүүд гэсэн сэдвүүдийг багтаан Монголын нууц товчоон зохиогдож дууссаны 777 жилийн түүхэн ойд зориулан нийтлүүлжээ.

63.3(1)+81.2М-3

П 915

/НХУУТ-5/

ЭШФ Т 24572-24576

Пүрэвжав Э. Монголын нууц товчоон судлалын чуулган: Боть II / Ред. Б.Цогтбаатар; Эх бэлт. П.Соёлмаа; Диз. П.Содбаатар.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 278х.- (Чингис хааны өв, соёлын хүрээлэн).- ISBN 978-9919-20-643-7.



Тус бүтээл нь хэл бичгийн ухааны доктор Эрдэнийн Пүрэвжавын бичиж нийтлүүлсэн 21 бүтээлийг багтаан "Монголын нууц товчоон" зохиогдож дууссаны 780 жилийн түүхэн ойд зориулан хэвлүүлжээ.

63.3(1)

П 915

/НХУУТ- 5/

ЭШФ Т 24577-24581

Чойбалсан Х. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх / Эрхлэн хэвл. Б.Даш-Ёндон, З. Лонжид, Х.Сайхансанаа; Эх бэлт. Д.Дүнчигмаа, Ш.Адъяа; Диз. Т.Мөнхдэлгэр, Э.Даваасүрэн.- 3 дахь хэвл.- УБ., 2021.- 276х.- ISBN 978-9919-24-562-7.



Энэ номонд 1911-1921 оны эхэн үе хүртэлх Монголын тухай нэлээд тодорхой мэдээ баримтууд багтжээ. Үүнд: 1911-1919, 1921 оны 2-оос 7-р сард Богд хааны буулгасан зарим зарлиг, 1921 оны 3 сараас 7 сарын эхэн хүртэл МАН-ын Төв хороо, Ардын түр Засгийн газраас гаргасан шийдвэр, Нийслэл хүрэн дэх монголын хувьсгалчид ба Хиагт дахь намын нөхдийн хоорондоо харилцаж байсан захидал болон бусад холбогдох түүхэн материалуудыг эмхэтгэсэн байна.


63.3(1)6

Ч 75

/НХУУТ-2/

/ЭШФ Б-30526-30528/

Ойрад судлалын номын сан= Bibliotheca oiratica.- УБ.: Соёмбо принтинг.



Цувр. ХСІХ: Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир: Дэвт. Илтгэл 8, 11-13; Шастир 52, 61-74, 79-91, 98-99 / Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Т.Ганцогт; Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Эх бэлт. Л.Энхсаруул, У.Анхдалайбаяр, Т.Ганцогт, Г.Эрхэмбаяр; Хэвлэлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Диз. Б.Эрдэнэбулган.- 2020.- 228х.- ISBN 978-9919-9617-7-0.


Сурвалж судлалын судалгаа амжилттай өрнөсөөр, энэ удаа "Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир"-ын Ойрад аймгуудын тухай өгүүлэх Илтгэлийн 8, 11-13; Шастирын 52, 61-74, 79-91, 98-99 дүгээр дэвтрүүдийг худам үсгээс хөрвүүлж, хятад эхтэй харгуулж тус цувралын энэхүү 99-рт хэвлэж байна.

63.5+63.3(1)

О-24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24582-24586



Цувр. С: Зарлигаар тогтоосон залгаж зохиосон гадаад мужийн монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир: Илтгэл 7-12; Шастир 7-12 / Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Т.Ганцогт; Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Эх бэлт. Л.Энхсаруул, У.Анхдалайбаяр, Т.Ганцогт, Г.Эрхэмбаяр; Хэвлэлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Диз. Б.Эрдэнэбулган.- 2020.- 188х.- ISBN 978-9919-9617-8-7.


Сурвалж судлалын судалгаа амжилттай өрнөсөөр, энэ удаа "Зарлигаар тогтоосон залгаж зохиосон гадаад мужийн монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир"-ын Ойрад аймгуудын тухай өгүүлэх Илтгэлийн 7-12; Шастирын 7-12 дугаар дэвтрүүдийг манж, хятадаас орчуулж тус цувралын энэхүү 100-рт хэвлэж байна.

63.5+63.3(1)

О-24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24587-24591



Цувр. СІ: Зая бандида Намхайжамцын намтрын судалгаа / Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Х.Бямбажав; Хэвлэлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Диз. Э.Доржханд.- 2021.- 140х.- ISBN 978-9919-9617-9-4.

Зая бандида Намхайжамц (1599-1662)-ын намтар түүх, Зая бандидын шавь Раднаабдраагийн бичсэн "Равжам Зая бандидын тууж Сарны гэрэл хэмээх оршив" хэмээх сурвалжийн судалгаа, Захчинаас олдсон эх бичгийн кирилл хөрвүүлэг, 620 гаруй түүхэн газар орон, түүхт хүмүүсийн нэр, бурхны шашны нэр томьёо, ном судрын нэрэнд танилцуулга, тайлбар хийсэн бүтээл болно.

63.5+86.35

О-24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24592-24596

Цувр. СII: [Өндөр] гэгээний намтар оршвой / Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Г.Ядамжав; Орчуулж, удиртгал бичсэн; На.Сүхбаатар; Хэвлэлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Диз. Э.Доржханд.- 2021.- 124х.- ISBN 978-9919-9654-0-2.



Тод үсгээр бичсэн "[Өндөр] гэгээний намтар оршвой" хэмээх сурвалжийн эх бичгийг гэрэл зургаар үзүүлж, крилл бичигт хөрвүүлэн дэлгэрэнгүй удиртгалын хамтаар хэвлүүлж байна. Уг зохиол нь Халхын анхдугаар богд Өндөр гэгээн Занабазарын намтар бөгөөд 1859 оны үед худам үсгээр нэр үл мэдэгдэх зохиогч зохиосон бөгөөд дараа нь тод үсгээр хөрвүүлсэн байна.

63.5+86.35

О 24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24597-24601

Гаваншарав. **Цувр. СIII:** Дөрвөн Ойрадын түүх / Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Х.Бямбажав; Хэвлэлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Хөрвүүлж, тайлбар бичсэн На.Сүхбаатар; Диз. Э.Доржханд.- 2021.- 140х.- ISBN 978-9919-9654-1-9.



Энэхүү бүтээл нь Оросын ШУА-ын Санкт-Петербургийн салбарын номын сангийн К.Ф.Голстунскийн цуглуулганд хадгалагдаж буй Е-66 дугаартай эхийн гэрэл зургийн үндэслэн хийсэн сурвалж судлалын судалгааны ажил бөгөөд кирилл хөрвүүлэг, тайлбар, эхийн гэрэл зураг, латин галиг, үгийн хэлхээсээс бүрджээ.

63.5+63.3(1)

О 24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24602-24606

Цувр. CIV: Дөчин дөрвөн хоёрын "Их цааз"-ын судалгаа / Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Б.Түвшинтөгс; Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Хэвлэлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Диз. Э.Доржханд.- 2021.- 172х.- ISBN 978-9919-9654-2-6.



Тус бүтээл нь 1640 онд Халх, Ойрадын их чуулганаар баталсан "Их цааз"-ын ОХУ-ын Түүхийн төв архивын Халимагийн фондод байгаа тод үсгийн эхийг гэрэл зургаар үзүүлж, эхийн галиг, үгийн хэлхээс үйлдэж, кирилл үсэгт орчин цагийн монгол хэлэнд буулгаж тайлбарласан судалгааны бүтээл болно.


63.5+67.3(1)

О 24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24607-24611

Цувр. CV: Ч.Далай - 90, түүх судлалын асуудлууд: Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл / Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Д.Золбоо; Эмхэтгэж, эрхлэн хэвл. На.Сүхбаатар, Ү.Мөнхдагва; Хэвлэлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Диз. Э.Доржханд.- 2020.- 160х.- ISBN 978-9919-9654-3-3.



Тус бүтээлд 2020 оны 09 сарын 04-нд Ховд аймгийн Зэрэг сумнаа хуралдсан Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич Чулууны Далай (1930-2009)-н мэндэлсний 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг эмхэтгэн


оруулсан болно. Илтгэлүүд нь академич Ч.Далайн намтар, эрдэм судлалын үйлс, бүтээлүүдийн судлал болон Ойрадын түүх, соёлын судалгааны сэдэвтэй юм.

63.5+63.3(1)

О 24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24612-24616



Цувр. XV: Бух ноолдоон: Эрдэм шинжилгээний өгүүллүүдийн эмхэтгэл / Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Б.Нанжид; Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Хэвлэлийн эх бэлт. Т.Энхтунгалаг; Диз. Б.Эрдэнэбулган.- 2020.- 136х.- ISBN: 978-9919-23-971-8.

Тус өгүүллийн эмхэтгэлд Ойрадын "Бух ноолдоон"-ы талаар судлаачдын бичсэн 13 өгүүллийг эмхэтгэн хэвлүүлж буй бөгөөд үүний 8 нь анх удаа нийтийн хүртээл болж байгаа өгүүлэл болно.

63.5+75.715

О 24

/НХУУТ-5/

ЭШФ Т 24617-24621



Энхбаатар М. **Малын тоног хэрэгсэл:** Аж ахуйн хэрэглээний толь / Ред. Г.Цэрэнханд; Монгол бичгийн бичвэрийг Б.Ариунжаргал; Эх бэлт. П.Номинцэцэг; Диз. Ц.Түмэнжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 180х.- ISBN 978-9919-24-014-1.

Энэхүү бүтээлд малын таван зуу орчим тоног хэрэгслийн төрлийг бүс нутгийн онцлогоор тодорхойлон тайлбар өгч, мал аж ахуйтай холбогдох мэдлэг ухааны уламжлалыг тод томруун гаргаж, нутаг нутгийн онцлог, нэр нэршил, үйл ажиллагааны олон тал мөн тоног хэрэгсэл хийх аргад, эд хэрэглэгдэхүүнийг нарийвчлан сонгох болон чухамхүү таван хошуу малын төрөл бүрд тохирох тоног хэрэгслийг хийхээс эдэлж дуусталх эдэлгээ, хэрхэн яаж эдэлбэл урт удаан байх болон мал, малчин хоёрын харилцааны талаар тусгажээ.


63.5(1)я2

Э 66

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т 24694-24698

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Чимгээ Д. ба бус. **Бизнесийн шинжилгээ ба шийдвэр гаргалт EXCEL програм дээр гүйцэтгэх нь** / С.Оюунсүрэн, А.Энэрэл; Ред. А. Болор; Эхийг бэлт. Ж.Амарсанаа.- УБ.: Арвай принт, 2021.- 140х.- (МУИС-БС-ХҮИС).

Энэ ном нь их, дээд сургуулийн оюутнуудад хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээ, бизнесийн мэдээллийн систем зэрэг хичээлийг EXCEL программын хэрэглээтэй холбон судлахад ашиглах сургалтын нэмэлт материал, гарын авлага болох юм. Мөн байгууллагын нягтлан бодогч, санхүүч, эдийн засагчид, бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын төслийн болон бизнесийн шинжилгээнд EXCEL программыг ашиглахад нь туслах ажээ.

65с

Ч 620

/НХУУТ-4, ГНОФ-3, БС-10/

ЭШФ Б 30541-30543

Хүмүүний газарзүй / Ред. В.Батцэнгэл, Р.Ринчинбазар, Б.Чинбат; Хэвлэлийн ред. Т.Ууганбаяр; Хян. Г.Бямбабаяр; Зураг схем бэлд. Ч.Наранцэцэг.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2021.- 534х.- ISBN 978-9919-504-53-3.



Энэхүү бүтээл нь газарзүйн тухай ойлголт, хүн амын газарзүй, улс төрийн газарзүй, соёлын газарзүй, эдийн засгийн газарзүй, хөдөө аж ахуйн газарзүй, аж үйлдвэрийн газарзүй, үйлчилгээний газарзүй, тээврийн газарзүй, хотын газарзүй, хөгжлийн газарзүй зэрэг агуулгыг багтаасан бөгөөд байгаль, нийгмийн ухааны чиглэлээр суралцаж буй оюутнуудын ерөнхий суурь боловсрол эзэмшихэд зориулагдсан ажээ.

65.04я73

X 821

/БУУТ-17, ГНОФ-30/

ЭШФ Т 24665-24667

Ариунболд Ж., Басбаяр Б. **Ирээдүйн хөдөлмөр эрхлэлт, боловсролын бодлогын уялдаа** / Орч. Ж.Ариунболд; Хян. С.Бадамцэцэг; Хэвлэлд бэлт. Д.Отгонбаатар, Б.Дашням.- УБ.: Инком принт, 2021.- 350х.- ISBN 978-9919-24-599-3.



Энэхүү бүтээлд ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа сурагчид ирээдүйд ямар их сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцвал ирээдүйн зорилгодоо хүрэх, их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад сурч буй оюутнууд ямар ур чадварыг илүү хөгжүүлбэл ажлын байранд тогтвортой ажиллах, боловсролын байгууллагад ажиллаж байгаа эрдэмтэд, судлаачид, багш нар, удирдлагуудад хөдөлмөр, боловсролын ирээдүйн чиг хандлагын тухай ойлголт, баялаг бүтээж буй компаниудад ямар сорилт бэрхшээл, боломж үүсэх тухай тайлбар зөвлөмжийг хүргэжээ.

65.240+74.0

A 751

/НХУУТ-2, ОУХНУС-5/

ЭШФ Т 24699-24700

Пүрэвдагва Х. **Чингис хааны менежментийн товчоон** / Ред. П.Очирбат, Д.Ганболд; Монгол бичигт буулгасан С.Оюунгэрэл, Ч.Оюунгэрэл; Хөрв. П.Анузаяа; Эх бэлт. Б.Баярбаатар.- 2 дахь хэвл.- УБ.: Жиком пресс, 2020.- 220х- ISBN 978-9919-23-511-6.



Зохиогч энэхүү бүтээлдээ Чингис хааны хүчирхэг удирдлагын арга барилыг орчин үеийн менежментийн шинжлэх ухааны онолын үүднээс задлан шинжилжээ. Үүнд: Тэмүжинд удирдагчийн шинж чанар төлөвшин тогтсон үе, Чингис хааны удирдлагын стратеги, түүний хэрэгжилт, удирдлагын тогтолцоо, хуваарилалт, бүрэн эрх, удирдах удирдуулах зарчим, удирдлагын коммуникаци, мотиваци, манлайлал болон удирдлагын залгамж холбоог бүхэлд нь авч үзсэн байна. Тус бүтээл нь Чингис хаан судлалд орж буй шинэ чиглэл төдийгүй Чингис хааны менежмент бол дэлхийн орчин үеийн менежментийн хөгжлийн үндэс болон даяаршиж буйг монголын нууц товчооны баримтаар нотлон үзүүлжээ.

65.290-2

П 915

/НХУУТ-3, БС-5/

ЭШФ Б 30544-30545



Наранчимэг Л. **Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээний онол арга зүйн асуудлууд** / Ред. Б.Сайнжаргал.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 154х.- ISBN 978-99962-858-2-0.

Энэхүү судалгааны ажилд Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн тоо мэдээллийг үндэслэн салбар бүрээр санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцож, санхүүгийн тайлангийн оновчтой бүтцийг хэрхэн тодорхойлох талаар тусгажээ.

65.290-93

Н 294

Цахим ном-102



Эрсдэлийн удирдлага-I: Компанийн санхүүгийн эрсдэлийн удирдлага: Нийгмийн хөгжил, шинэчлэлийг манлайлагч удирдах ажилтны гарын авлага / А.Ганзориг, П.Баянсан, С.Цолмон, Т.Ууганбаяр; Хян. Б.Сайнжаргал, Д.Моломжамц, Б.Сайнжаргал; Эх бэлт. Э.Батболд.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг.- 400х.- ISBN 978-99978-2-547-6.- (CD-тэй).

Энэ ном нь эрсдэлийн удирдлагын үндэс, бизнесийн эрсдэлийн хүчин зүйлийн бүдүүвч, бизнесийн эрсдэлийн үнэлгээний үзүүлэлт, аж ахуйн нэгжийн төлбөрийн чадварын эрсдэлийн үнэлгээний загвар, бизнесийн төлөвлөлтийн эрсдэлийг үнэлэх загвар, бизнесийн эрсдэлтэй шийдвэр гаргах шалгуур, бизнесийн эрсдэлийг удирдах нь, компанийн санхүүгийн эрсдэлийн шинжилгээ, багц сонголтын тооцооны үндэслэл гэсэн 9 бүлгээс бүрдэнэ.

65.290-93я7

Э 765

/НХУУТ-3, БС-5/

ЭШФ Т 24552-24553



Лхамцэдэн Б. **Зочид буудлын үйлчилгээний удирдлага.**- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 324х.- ISBN 978-9919-24-629-7.

Энэхүү бүтээлд аялагч жуулчид, зочдод хамгийн таатай орчин бүхий найрсаг, чанартай үйлчилгээг үзүүлэхээр чармайн ажилладаг зочид буудлын мэргэжлийн багийн удирдлага зохион байгуулалт, алба нэгж, ажилтнуудын ажил үүрэг, хариуцлагыг тайлбарласны дээр үйлчилгээний онол, арга зүйн үндэс, зочид буудлын удирдлага, түүний дотор хүлээн авах алба, зоогийн газрын болон өрөөний үйлчилгээ, цэвэрлэгээний албадын үйл ажиллагааг нарийвчлан тусгажээ.

65.43

Л 874

/НХУУТ-5, БС-3/

ЭШФ Т 24507-24509



Доржсүрэн Н. **БНАСАУ-ын бие даасан Эдийн засгийн хөгжлийн бодлого ба сорилтууд** / Ред. Э.Мөнхдулам.- УБ., 2021.- 175х.- ISBN 978-9919-24-525-2.

Энэхүү бүтээлд БНАСАУ-ын бие даасан эдийн засгийн хөгжлийн суурь болох төлөвлөгөөт эдийн засгийн үзэл санааны үүсэл, эдийн засгийн системийн төрөл болон социалист төлөвлөгөөт эдийн засагтай орнуудад хийгдэж байсан реформын шинж чанартай шинэчлэл өөрчлөлтүүд, БНАСАУ-ын бие даасан эдийн засгийн хөгжлийн

түүхийг он дарааллаар авч үзсэнээс гадна хоёр Солонгосын эдийн засгийн харилцааны асуудал, тус улсын хөрш орнууд болох БНХАУ, ОХУ-ын БНАСАУ-ын эдийн засаг дахь байр суурь, Монгол улс, БНАСАУ-ын эдийн засгийн харилцаа болон өнөөгийн нөхцөл байдал цаашид хэрхэн хөгжүүлэх боломжийн талаар тусгажээ.

65.5
Д 543

ОУХНУС 5709-5713

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

БНСУ, Монголын түүхийн харилцааны ололт амжилт ба хэтийн төлөв / Орч. Э.Баярмаа, Л.Мөнхнаран, Г.Баярмаа, Ц.Баярмаа; Эрхл. Кан СоньХуа, Б.Булган; Эх бэлт. Б.Мөнх-Эрдэнэ.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 181х.



Энэхүү бүтээлд өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол, Солонгосын түүхч, археологич эрдэмтдийн хамтран гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний олон ажлуудын үр дүнг дүгнэсэн дүгнэлт, мөн цаашид хоёр улс хамтран хийх боломжтой ажлуудын төлөв байдлын тодорхойлолт багтжээ.

66.4 (5CoӨ)
Б 823

/ХЗС-3/

ЭШФ Т 24632-24634

Монгол Ардын Намын түүхт найман жил / Ред. З.Лонжид; Боловс. А.Алтанбагана, Ч.Болдбаатар; Диз. Т.Мөнхдэлгэр, Д.Даваасүрэн.- УБ., 2021.- 305х.- ISBN 978-9919-24-561-0.



Энэхүү бүтээлд МАХН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадоржийн МАХН-ын байдал, "МАХН-ын таван жилийн ой" (хамтын өгүүлэл), МАХН-ын Хянан байцаах төв комиссоос эрхлэн гаргасан "Хянан байцаасан нь" зэрэг зохиол, өгүүллийг эмхтгэн, эрдэм шинжилгээний тайлбар, зүүлтийн хамтаар оруулсны дээр тухайн үеийн гадаад, дотоод нөхцөл байдал, хэрэг явдлыг дургал байдлаар өгүүлжээ.

66.61(1)
М 692

/НХУУТ-2/

ЭШФ Б 30523-30525

Монгол Ардын Намын 100 жилийн түүхийг хураангуйлсан 100 карт.- УБ., 2021.- 100х.



Энэхүү бүтээл нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёл боловсрол зэрэг бүхий л салбарын бүтээн байгуулалт ололт амжилтын 100 жилийн хөгжлийн түүхийг харуулсан зурагт хуудаснуудаас бүрдэнэ. Эдгээр картууд нь он дарааллаар байрласан бөгөөд фото зургийн ар талд холбогдох тайлбарыг бичсэн нь товч, тодорхой түүхэн мэдээ баримтыг нэг доороос үзэх боломжтой ажээ.

66.6(1)
М 692

ЭШФ Б 30554-30558



XXVIII их хурал илтгэл, зүтгэл, хариуцлага: Илтгэл, баримт бичгүүд / Эхийг баталсан Д.Амарбаясгалан; Хян. Б.Баярбаатар, Х.Сайхансанаа; Эх бэлт. Д.Дүнчигмаа, Б.Баасанжаргал, Б.Эрдэнэбат; Диз. Т.Мөнхдэлгэр, Ч.Мөнхжаргал, Э.Даваасүрэн.- УБ., 2021.- 169х.- ISBN 978-9919-24-563-4.

Энэхүү бүтээлд МАН-ын XXVIII их хурлаар хэлэлцсэн улс төрийн илтгэл, ажлын тайлан, намын дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийн тухай мэдээлэл анхдугаар хуралдааны зарим тогтоол зэрэг багтжээ.

66.61(1)

X 478

/НХУУТ-2/

ЭШФ Т 24641-24643

ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН



Долгоржав Я. Төрийн захиргааны шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн тойм / Техник ред. М.Энхтуул.- УБ.: Хүслийн өнгө, 2020.- 83х.- ISBN 978-9919-20-761-8.

Энэхүү бүтээл нь төрийн захиргааны шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн үе шат, төрийн захиргааны шинжлэх ухааны шинэчлэл, онолын парадигмын өөрчлөлт, хөгжлийн даяаршмал хандлага, түүний нөлөө Монгол улсад тусч байгаа нь, төрийн захиргааны шинэ үзэл, улсын салбарын шинэ удирдлага буюу New Public Management, олон түмний засаглал буюу Public Governance, төрийн захиргаа хийгээд олон түмний (public) үнэт зүйлийн өөрчлөлт, төрийн удирдлага ба цахим засаглал гэсэн сэдвийн хүрээнд бичигджээ.

67

Д 464

ОУХНУС 5714-5723



Сэнгэдорж Т. Хууль зүйн шинжлэх ухаан: Судалгааны арга зүй.- УБ.: Адмон, 2021.- 200х.

Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүйн энэхүү бүтээлд шинжлэх ухааны ерөнхий шинж төлөв, шинжлэх ухаан ба төрийн бодлого, шинжлэх ухаан ба эрх зүй, хууль зүйн шинжлэх ухааны хөгжил, хандлага, судалгааны арга зүйг авч үзсэн байна. Түүнчлэн сэдэв сонгох, судлах, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бэлтгэх, бакалаврын диплом, магистрын ажил, докторын диссертаци бичих арга зүй, эрдмийн ажил хамгаалахад анхаарах асуудлын талаар өгүүлжээ.

67

С 941

/ХЗС-10, НХУУТ-3/

ЭШФ Б 30577-30578

Шүүх эрх мэдэл: Мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл: №1 / Ерөн. эрх. Э.Батбаяр; Гишүүд Д.Цогтсайхан, Л.Алтанцэцэг, Г.Банзрагч ба бус.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 141х.- (Шүүхийн ерөнхий зөвлөл).- ISBN 978-99962-3-728-7.

Тус цуврал эмхэтгэлд шүүх судлал, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, шүүгчийн индэр, шүүгч таны мэдлэгийн санд гэсэн агуулгын хүрээнд монголын эрдэмтэн судлаачдын судалгааны 14 өгүүлэл нийтлэгдсэн байна.



67

Ш 978

XЗС 22208-22210

Баярсайхан Д. **Эрх зүйн онол** / Эх бэлт. Д.Энхнаран.- 6 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 307х.- ISBN 978-99929-69-98-9.

Энэ удаа хэвлэн гаргаж буй эрх зүйн онол нь хууль зүйн шинжлэх ухааны сүүлийн үеийн ололт, үр дүнг бүтээлчээр тусгаж, англи хэл дээр хэвлэгдсэн эрх зүйн онолын эх сурвалж, ном, сурах бичиг, онол, арга зүйн сэтгүүлүүдийг аль болох өргөнөөр ашиглахыг эрмэлзсэнээрээ өмнөх бүтээлээс ялгаатай. Уг номонд эрх зүйн философийн категори, ухагдахуун зохих хэмжээнд тусгалаа олсны дээр харьцуулсан эрх зүй судлалын онолын тулгамдсан асуудлууд ч хөндөгджээ.



67.0


Б 387

/XЗС-25, НХУУТ-3, ГНОФ-5/

ЭШФ Т 24739-24740

Лүндэндорж Н. **Төрийн онол**: Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Шилдэг сурах бичиг”.- 4 дэх хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 368х.- ISBN 99929-0-587-5.

Энэхүү бүтээлд төрийн мөн чанар, түүхэн хэв маяг, чиг үүрэг, хөгжлийн ерөнхий зүй тогтол, Үндсэн хуульт ардчиллын үе дэх уламжлалт төрийн хувьсал өөрчлөлт, онол арга зүйн зөрөө, даяаршлын нөлөөлөл, төрийн үүсэл хөгжлийн тухай онол сургаалууд, тэр дундаа нийгмийн гэрээний онол, төрийн болон ард түмний бүрэн эрхт байдал, уламжлалт болон орчин үеийн төрийн шинж, ангилал, хэлбэр ардчилсан болон ардчилсан бус төрийн хэтийн төлөв, уламжлалт нийгэм дэх төрийн чиг үүрэг болон либераль нийгэм дэх Үндсэн хуульт төрийн чиг үүргийн ялгаа, эрх зүйт ёс /Rule of law/, үндсэн хуульт ёсны үүднээс төрд хандах арга зүй, даяаршлын нөлөө улс үндэстний өөрчлөлт зэрэг агуулгыг тусгасан байна.



67.0я73

Л 871

XЗС 22092-22101



Эрх зүй Онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл=NUM law review / Сэтгүүлийн зөвлөлийн дарга Ж.Эрдэнэбулган; Гишүүд С.Нарангэрэл, Д.Баярсайхан, Х.Сэлэнгэ ба бус.; Нарийн бичгийн дарга А.Бямбажаргал; Ажлын алба Б.Батбаяр.- УБ., 2020.- (МУИС-ХЗС).- ISSN 2226-9037.

Тус сэтгүүлүүдэд нийтийн эрх зүй, хувийн эрх зүй, процессын эрх зүй, судалгааны үр дүн, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ гэсэн сэдвийн хүрээнд нийт 60 гаруй өгүүлэл хэвлүүлжээ.

67.0(1)

Э 81

№1: Цувр. 49.- 277х.

XЗС 22139-22148

№2: Цувр. 50.- 303х.

XЗС 22149-22158

№3: Цувр. 51.- 391х.

XЗС 22159-22168

№4: Цувр. 52.- 396х.

XЗС 22169-22178

№1: Цувр. 53.- 339х.

XЗС 22179-22188



Нарангэрэл С. Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг: Хууль зүйн нэр томъёо ба ухагдахуунтай / Хян. Х.Нямбаатар; Техник ред. А.Солонго; Эх бэлт. Д.Оюун.- УБ.: Адмон принт, 2021.- 638х.- ISBN 978-9919-24-948-9.

Энэхүү толь бичигт нийтийн (үндсэн хуулийн, захиргааны, эрүүгийн, экологийн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны) ба хувийн (иргэний, хөдөлмөрийн, гэр бүлийн зэрэг) эрх зүйн түүнчлэн олон улсын нийтийн ба хувийн эрх зүйн зэрэг бүх салбар эрх зүй хийгээд дэлхийн болон монголын төр эрх зүйн онол, түүх ба криминологи, шүүхийн шинжилгээ зэрэг хууль зүйн хэрэглээний (хавсарга) судлагдахууны тайлбар өгүүллийг багтаажээ.

67(1)я2

Н 294

XЗС 22219-22238



Баярсайхан Б. Монголын эрх зүйн түүх, соёлын судалгаа: Илтгэл, өгүүлэл.- УБ.: Адмон, 2021.- 466х.- ISBN 978-9919-21-292-6.

Тус бүтээл нь Монголын эрх зүйн түүхийн судалгаа, Монголын эрх зүйн түүхэн эх сурвалжийн судалгаа, Монголын эрх зүйн сэтгэлгээ, соёлын хөгжил гэсэн үндэс 3 бүлгийн хүрээнд Б.Баярсайханы судалгааны илтгэл, өгүүлүүдээс түүвэрлэн уншигч олондоо толилуулжээ.

67.3(1)

Б 387

XЗС 22239-22248

Бурмаа Н. **Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит.**- УБ., 2021.- 415х.- (МУИС-ОУХНУС).- ISBN 978-9919-24-023-3.

Тус бүтээлд хяналт, шинжилгээ, үнэлгээ, мониторинг, аудитын ойлголтыг онолын үүднээс тайлбарлан, хүний нөөц хүмүүн капиталын удирдлага, бодлого, төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, хяналтын уялдаа холбоог хүний нөөцийн оновчтой удирдлага, аудитын үр дүнтэй холбон үзэж, түүнийгээ ойлгомжтой дэлгэрэнгүй тусган харуулжээ.



67.401я73+65.053

Б 769

/НХУУТ-7, БС-3/

ЭШФ Т 24674-24676

Бурмаа Н. **Төрийн үйлчилгээ.**- УБ., 2021.- 460х.- (МУИС-ОУХНУС).- ISBN 978-9919-24-057-8.

Энэхүү бүтээлд төрийн удирдлага, нийтийн удирдлага, нийтийн захиргаа, төрийн захиргааны менежмент, "улсын салбарын удирдлага" хэмээх ойлголт, хараахан нэгдмэл ойлголт болон хэвшээгүй харин "public administration" хэмээх ойлголтыг тойрч, түүний үндсэн агуулгыг тодотгосон шинжтэй бусад олон нэр томьёо, туслах ойлголтууд бий болсон талаар дурджээ.



67.401я73

Б 769

/НХУУТ-7, ГНОФ-5, БС-5/

ЭШФ Т 24671-24673

Овен Е. Хьюс. **Төрийн захиргаанаас нийтийн удирдлагад** / Ред. П.Наранбаяр, Ү.Ганболд; Орч. Ц.Даваадулам.- 5 дахь хэвл.- УБ.: Эдмаркет, 2020.- 334х.- ISBN 978-9919-20-838-7.

Тус номын зохиогч Овен Е.Хьюс нь 1980-аад оны дунд үеэс барууны орнуудын төрийн захиргаанд бий болсон даяарчлал, технологийн өөрчлөлт, өрсөлдөөнийг дагасан шинэчлэл идэвхжилтэд судалгаа хийж, уламжлалт болон орчин үеийн төрийн удирдлагын загварыг харьцуулсан төрийн шинэ менежментийн онол, зарчмын асуудлыг дэвшүүлжээ.



67.401я73

О 134

ОУХНУС 5736-5744

Гантулга С., Энхболд Б. **Эрүүгийн эрх зүй:** Тусгай анги.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 495х.- ISBN 978-99978-3-633-5.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тусгай анги бол эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн бие даасан салшгүй нэг хэсэг юм. Зохиогч эрүүгийн материаллаг ба процессын хэм хэмжээг хэрэглэх, эрүүгийн хэргийг мөрдөх, яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн эрх зүйн онол, арга зүйн мэдлэг, практик, хууль зүйн зохицуулалт ус агаар мэт хэрэгцээтэй байгааг бодолцон үзэж эрүүгийн эрх зүйг хэрэгжүүлэх хуульчдын өдөр тутмын үйл ажиллагаа, хууль зүйн их, дээд сургууль, коллежийн оюутан, сонсогч нарт хичээл сургалт, шалгалт шүүлэг, реферат бие даалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд нь тус нэмэр болох үүднээс энэхүү номоо бүтээжээ.



67.408я73

Г 233

ХЗС 22090



Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа / Боловс. М.Гантулга, Г.Цэцэгмаа, Б.Бат-Орших ба бус.; Хян. М.Гантулга.- УБ.: Урангар пресс, 2020.- 136х.

Энэхүү бүтээлд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх олон улсын хамтын ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалт, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхэд прокурорын үүрэг, оролцоо, анхаарах асуудлууд, гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгийг шалгаж тогтоох, битүүмжлэх, буцаан авах ажиллагааны зөвлөмжүүд зэрэг багтжээ.

67.408я7

Г 924

ЭШФ Б 24622



Доржпалам Х. **Монгол улсын эрүүгийн эрх зүй**: Тусгай анги: Онол, практикийн асуудал / Хян. Ж.Эрдэнэбулган; Эх бэлт. Л.Амаржаргал.- УБ.: Сэлэнгэ пресс, 2021.- 380х.- ISBN 978-9919-24-047-9.

Уг бүтээлд Эрүүгийн эрх зүйн тусгай ангийн ойлголт, судлагдахуун, тогтолцоо; Хүний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийн тухай ойлголт, Эрүүл мэндийн гэмт хэргүүдийн тухай ойлголтууд болон Хүүхдийг эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, Үндэсний аюулгүй

байдлын эсрэг гэмт хэргүүдийн тухай ойлголт төрөл анги, шинжүүдийн тухай тусгажээ.

67.408(1)

Д 542

/НХУУТ-4, ГНОФ-3, ХЗС-20/

ЭШФ Т 24554-24556



Судалгааны тайлан эмхэтгэл: 2016-2019: Боть III / Хян. З.Баасанням, Ц.Шинэбаяр; Боловс. Ц.Бадам.- УБ.: Урангар, 2019.- 414х.- (Авлигатай тэмцэх газар).- ISBN 978-9919-22-716-6.

Энэхүү 3-р ботид 2008-2018 онд зохион байгуулсан Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа, 2009, 2011, 2013 онуудад зохион байгуулсан Авлигын индексийн судалгаа, 2010, 2012, 2014 онуудад зохион байгуулсан Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ, 2015, 2016, 2018 онд зохион байгуулсан Шударга байдлын үнэлгээ, 2010 оноос 2019

онд зохион байгуулсан Хүүхдийн шударга байдлын судалгаа, 2018 онд зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт хандлагыг тодорхойлох судалгаа багтжээ.

67.408(1)

С 701

ЭШФ Т 24660-24661

Буянхишиг Б. **Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй** / Хян. Э.Отгонзул.- УБ.: LIAPubl, 2021.- 214х.- ISBN 978-9919-24-260-2.

